

ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛД ОРОЛЦСОН ТУХАЙ

Бүгд Найрамдах Солонгос Улсын Сеул хот дахь Хөнхийн их сургуулиас 1992 оны 9-р сарын 15-16-нд засхон байгуулсан "XXI зуун дахь ардчилал, Дэлхийн шинэ дэглэм" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний семинар-бага хуралд ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төвийн захирал доктор, профессор Ч. Далай, эрдэм шинжилгээний ажилтан, доктор Г. Сүхбаатар нар оролцов. Бага хуралд НҮБ-ийн Ерөнхий чарийн бичгийн даргын туслах Эрик Жэнсен, Оросын Холбооны Улсын физикч, нобелийн шагналт А. М. Прохоров, Их сургуулиудын захирлуудын олон улсын холбооны Энхтайвны төлөө дээд комиссын дарга, доктор Чой Юнсек зэрэг Орос, Солонгос, Англи, АНУ, Япон, - Хятад, Итали, Тайван, Бразилийн нэрд гарсан эрдэмтэд оролцон, илтгэл тавьж үг хэлэв.

Доктор Чой Юнсек /Хөнхийн их сургууль/ "XXI зуун дахь ардчилал, НҮБ-ын Энхтайвны ивээлийн Дэлхийн шинэ дэглэм" гол илтгэлдээ Францын хувьсгал бол 1-р ардчилсан хувьсгал мөн, Оросын Октябрийн хувьсгал бол 2-р ардчилсан хувьсгал мөн гээд XXI зуунд НҮБ-ын Энхтайвны ивээлээр капиталист ардчилал, социалист ардчиллын давуу талуудыг агуулсан шинэ ардчилал, Дэлхийн шинэ дэглэм тогтох болно гэв. Ч. Далай 4-р салбар хуралдаанд хүмүүсийн илтгэлтэй холбогдуулан үг хэлэв. Г. Сүхбаатар 4-р салбарт тавьсан "XXI зуун дахь ардчилал ба байгалийн хууль" илтгэлдээ Ф. Фукуямагийн /АНУ/ бичсэнээр XXI зуунд либерал ардчилал ялж түүхийн төгсгөл болохгүй, харин тусгаар тогтносон улсууд олноор бий болон түүхийн эхлэл болж, экологийн ардчилал ноёрхох болно гэв.

Тус бага хуралд олон орны гэрт эрдэмтэд оролцон, XXI зууны ардчиллын талаар маш үнэтэй дүгнэлт, санга, санал тавьсан нь чухал ач холбогдолтой болов.